



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 16 өдөр

Дугаар A/252

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Цахим сүлжээ сайжруулах гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх (Сэлэнгэ сум) ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Эм Ти Си Сервис" ХХК-тай 59,852,710 (тавин есөн сая найман зуун тавин хоёр мянга долоон зуун арав) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгэх хүлээлгэн өгөхийг "Эм Ти Си Сервис" ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Баяртуяа)-д даалгасугай.

3. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010362

Аймгийн Засаг даргын 2015 оны
04 дүгээр сарын 16-ний өдрийн
A/252 дугаар захирамжийн хавсралт

Д/Д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Гэрээ байгуулсанаас хойш хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн
2	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Д.Батцогт Ү.Бямбасүрэн
3	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Д.Батцогт
4	Захиалагчийн техник хяналтын зардал	1,039,290 төгрөг	Ү.Бямбасүрэн
5	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	519,645 төгрөг	Ү.Бямбасүрэн
6	Магадлашгүй ажил	1,039,290 төгрөг	Ү.Бямбасүрэн